



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/25/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН ЦЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Б.Одбилэг

Утас: 70272287 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГУМС	Засгийн газрын удирдлага мэдээллийн систем

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 9/219.
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 42 зорилт 143 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр батлагдан, хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар 94.85 хувьтай буюу "Үр дүнд хүрсэн" гэж дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ нь 8 зорилт, 31 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батламжлагдсанаас гүйцэтгэлээр 18 арга хэмжээ 100 хувь, 13 арга хэмжээ 70-88 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төв аймгийн Цээл сумын Засаг дарга тайлант онд түүхт ойн бүтээн байгуулалтын жилийн хүрээнд иргэдийн санал санаачилгаар сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургуулийн гадна тохижилтын ажилд 132,523.9 мянган төгрөг, сумын төвийн тохижилтын ажилд 134,491.8 мянган төгрөг, малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр 28,000.0 мянган төгрөгийг зарцуулан холбогдох данс бүртгэлд тусгаж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022.12.31	2023.12.31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		718,665.20	898,052.40
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	328,707.00	484,889.70
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	251,737.00	234,647.70
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	138,221.20	178,515.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		2,122,716.40	2,311,243.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	2,122,716.40	2,311,243.70
39200	Биет хөрөнгө		1,696,302.00	1,884,857.70
39300	Биет бус хөрөнгө	13	426,414.30	426,386.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,841,381.60	3,209,296.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,243.10	852.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	1,243.10	852.9
41300	Өглөг	17а, 17б	1,243.10	852.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,840,138.40	3,208,443.30
51	Засгийн газрын хувь оролцоо		2,840,138.40	3,208,443.30
51100	Засгийн газрын оруулсан капитал		716,990.20	716,990.20
51200	Хуримтлагдсан үр дүн		1,807,988.10	2,176,382.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		315,160.10	315,070.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,841,381.60	3,209,296.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022.12.31	2023.12.31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,590,929.6	1,915,491.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		274,731.8	392,692.8
110	Орлогын албан татвар		166,909.2	231,152.1
1100	Хувь хүний орлогын албан татвар		176,504.2	242,152.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-9,595.1	-11,000.0
113	Хөрөнгийн албан татвар		58,899.4	57,228.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		48,923.2	104,312.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	459,896.3	281,465.6
120	Нийтлэг татварын бус орлого		459,896.3	281,465.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,856,301.4	1,241,333.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,253,670.9	1,503,786.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,053,085.7	1,374,916.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,056,274.6	1,372,642.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		329,909.3	482,758.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		39,555.2	59,324.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		397,064.0	73,087.8
2104	Хангамж, бараа материалын зардал		38,552.4	52,240.0
2105	Нормативт зардал		72,537.4	92,220.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,040.2	1,621.0
2107	Томилолт, зочны зардал		4,143.5	7,168.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,754.7	395,064.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		162,717.9	209,158.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		996,811.1	2,274.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		200,585.2	128,869.9

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		337,258.7	411,705.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		3,801,727.3	42,860.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-3,464,468.6	368,845.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,432,896.9	0.0	6,432,896.9
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,304,607.1	0.0	6,304,607.1
9	Тайлант үеийн үр дүн	-3,464,468.6	0.0	-3,464,468.6
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,840,138.4	0.0	2,840,138.4
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,840,138.4	0.0	2,840,138.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,839,687.7	0.0	2,839,687.7
19	Тайлант үеийн үр дүн	368,845.1	0.0	368,845.1
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,208,443.3	0.0	3,208,443.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022.12.31	2023.12.31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		2,285,769.6	1,855,943.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО		274,731.8	392,692.8
110	Орлогын албан татвар		166,909.2	231,152.1
1100	Хувь хүний орлогын албан татвар		176,504.2	242,152.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-9,595.1	-11,000.0
113	Хөрөнгийн албан татвар		58,899.4	57,228.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		48,923.2	104,312.7
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		7,695.8	33,948.2
1181	Газрын төлбөр		39,422.2	68,277.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		1,805.2	2,086.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		154,582.3	221,917.6
120	Нийтлэг татварын бус орлого		154,582.3	221,917.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,856,455.4	1,241,333.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,941,213.8	1,253,332.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,941,213.8	1,253,332.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		937,963.4	1,248,048.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		294,038.6	481,706.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		35,671.6	58,997.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		397,064.0	73,223.8
2104	Хангамж, бараа материалын зардал		30,783.9	25,648.3
2105	Нормативт зардал		60,684.5	102,242.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,610.0	4,800.0
2107	Томилолт, зочны зардал		3,907.5	7,168.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		43,992.0	403,575.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		63,211.2	90,686.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,003,250.4	5,284.5

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		344,555.7	602,611.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		217,012.0	405,968.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		217,012.0	405,968.4
2200	Дотоод эх үүсвэрээр		217,012.0	405,968.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-217,012.0	-405,968.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-61,195.0	-40,460.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		61,195.0	40,460.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		66,348.6	156,182.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		262,358.4	328,707.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		328,707.0	484,889.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,778,084.2	1,464,626.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,126,463.0	1,093,298.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,122,463.0	1,089,872.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	463,976.0	447,449.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,122.1	54,733.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	457,846.8	450,335.1
2104	Хангамж, бараа материалын зардал	18,736.6	18,710.5
2105	Нормативт зардал	1,000.0	1,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,950.0	9,950.0
2107	Томилолт, зочны зардал	7,107.5	7,050.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,011.5	20,167.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,712.5	80,477.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,000.0	3,425.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	586,621.2	330,867.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	65,000.0	40,460.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,778,084.2	1,566,628.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	349,529.2	340,779.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,131,693.0	1,158,646.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	296,862.0	67,202.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	219,064.2
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	321,066.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	58	58
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	28
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	28

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,806.8	134,774.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,806.8	74,946.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,806.8	66,844.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	34,257.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	4,264.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,224.2	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4,082.5	6,236.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,800.0	605.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,700.1	21,481.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	8,102.4
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	8,102.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	59,828.1
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	59,828.1
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,806.8	134,774.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,806.8	134,774.5
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Цээл сумын Засаг дарга нь орон нутагтаа бүх шатны хурлын шийдвэр Засгийн газар, аймаг, сумын стратеги зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, төр, засгийн бодлого шийдвэрийг иргэдэд сурталчлан таниулж, хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, хөдөлмөр эрхлэлтийн чанарыг ахиулан амьжиргааны түвшнийг дээшлүүлж, байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, төрийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлж, сумын эдийн засгийн чадамжийг сайжруулан өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Цээл сумын Засаг дарга төрийн хуулийг дээдлэн хүндэлж иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй, ил тод, нээлттэй хүргэн ард иргэдийнхээ амьжиргааны түвшин дээшлүүлэх замаар сум орон нутгаа хөгжүүлэхэд оршино гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант онд Нийгмийн хариуцлагын хүрээнд Газар тариалангийн Шинэ залуучууд ХХК Ерөнхий боловсролын сургуулийн Б байрны их засварыг 174,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгэж хичээллэх боломжтой болгосон бөгөөд сайжруулалтаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, мөн Цүй хан инвест ХХК нь стандартын хог ангилан хаях 1,200.0 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг хогийн савыг ЗДТГ-т нийлүүлсэн байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг дарга тайлант онд түүхт ойн бүтээн байгуулалтын жилийн хүрээнд иргэдийн санал санаачилгаар сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Ерөнхий боловсролын сургуулийн гадна тохижилтын ажилд 132,523.9 мянган төгрөг, сумын төвийн тохижилтын ажилд 134,491.8 мянган төгрөг, малын үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр “Мон билярд” үйлдвэрийн 9 ш бух 8,000.0 мянган төгрөгөөр худалдан авч малчдад хариуцуулан маллуулж байгаа бөгөөд санхүүгийн тайланд тусгаж ажилласан байна.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 42 зорилт 143 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр батлагдан, хэрэгжилтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар 94.85 хувиар дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээ нь 8 зорилт, 31 хэрэгжүүлэх арга хэмжээтэй батламжлагдсанаас гүйцэтгэлээр 18 арга хэмжээ 100 хувь, 13 арга хэмжээ 70-88 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Цээл сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 4, 8, 10, 12, 23, 24, 28, 30 дугаар зүйл,
- Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар бүлэг, 4, 11, 13, 20, 41, 57, 59, 66 дугаар зүйл,

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3, 8, 46 дугаар зүйл

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн "Дотоод хяналтын зөвлөл шинэчлэн батлах тухай" А/193 захирамжаар томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын дотоод хяналтын зөвлөл нь тайлант онд дотоод хяналт шалгалтыг улирлаар төлөвлөн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Цээл сумын Засаг дарга 2021 онд батлагдсан 5 бүлэг бүхий Төв аймгийн төсвийн байгууллага, төсөл сангуудын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 367,914.5 мянган төгрөгөөр буюу 12,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	328,707.00	484,889.70	156,182.70
Авлага	251,737.00	234,647.70	-17,089.30
Бараа материал	138,221.20	178,515.00	40,293.80
Үндсэн хөрөнгө	2,122,716.40	2,311,243.70	188,527.30
Нийт хөрөнгө	2,841,381.60	3,209,296.10	367,914.50
Өр төлбөр	1,243.10	852.90	-390.20
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,840,138.40	3,208,443.30	368,304.90
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,841,381.60	3,209,296.20	367,914.60

Эх сурвалж: Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 156,182.7 мянган төгрөгөөр өсөж 484,889.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна. Тайлант онд орон нутгийн орлого 117,756.2 мянган төгрөг нь давсан орлогын үлдэгдэл, орон нутгийн хөгжлийн сан 247,351.7 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын хийгдээгүй ажлын үлдэгдэл, хоршоо хөгжүүлэх сангийн 73,714.1 мянган төгрөгийн үлдэгдэл, 46,067.1 мянган төгрөгийн эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл тус тус нөлөөлсөн байна.

Авлага дансны үлдэгдэл 234,647.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 17,089.3 мянган төгрөгөөр буурсан нь, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн авлага буурснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 178,515.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 40,293.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газар 39,199.0 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 183.2 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 911.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 2,311,243.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 188,527.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Засаг даргын Тамгын газар 180,574.6 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 4,143.2 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сан 3,809.5 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 1,243.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 852.9 мянган төгрөг болж 390.2 мянган төгрөгөөр буурсан байна. Тайлант онд Засаг даргын Тамгын газрын өр 103.0 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өр 365.6 мянган төгрөг нэмэгдэж, Эмийн эргэлтийн сангийн өр 861.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 3,208,443.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 368,304.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 830,061.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 812,393.7 мянган төгрөгөөр буюу 50,5 хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Кассад байгаа бэлэн мөнгө			
Банканд байгаа бэлэн мөнгө	328,707.00	484,889.70	156,182.70
Төгрөг	328,707.00	484,889.70	156,182.70
Төрийн сангийн харилцах	280,117.20	438,822.60	158,705.40
Арилжааны банк дахь харилцах	48,589.80	46,067.10	-2,522.70
Дүн	328,707.00	484,889.70	156,182.70

Эх сурвалж: Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн хөрөнгийн тодруулга тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 484,889.7 мянган төгрөг нь төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд 438,822.6 мянган төгрөг, арилжааны банкны дансанд 46,067.1 мянган төгрөг байршиж байна. Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны 438,822.6 мянган төгрөгийн 26,8 хувь буюу орон нутгийн ерөнхий орлогын 1,176,756.2 мянган төгрөг, 56.4 хувь буюу Орон нутгийн хөгжлийн сангийн 247,351.7 мянган төгрөг 16,8 хувь буюу Хоршоо хөгжүүлэх сангийн 73,714.6 мянган төгрөгийн үлдэгдэл байршиж байна.

Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл нь 156,182.7 мянган төгрөгөөр буюу өмнөх оноос орон нутгийн төсвийн орлогын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 56,703.2 төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 75,259.7 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгө 26,742.4 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Арилжааны банк дахь харилцах данс буюу эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл 2,522.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт

1. Төв аймгийн Цээл сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 02 тоот “Цалин шинэчлэн тогтоох тухай” тушаалаар төрийн албаны улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 2,525.3 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт бичив.
2. Цалингийн сан орон тоо батлагдаагүй байхад нягтлан бодогчид Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2023 оны 12 дугаар сарын Б/15 тоот тушаалаар 344.6 мянган төгрөгийн цалин олгосон зөрчилд төлбөрийн акт бичив.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 369,606.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 59,935.4 мянган төгрөгөөр буюу 19,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагаас авах авлага	26,068.0	102,169.8	76,101.8
Хувь хүмүүсээс авах авлага	225,645.8	132,454.7	-93,191.1

Дүн	251,647.7	234,647.7	-17,089.3
-----	-----------	-----------	-----------

Эх сурвалж: Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн авлагын тодруулга тайлан

Авлагын үлдэгдэлд Хоршоо хөгжүүлэх сангийн 201,974.2 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага 86,0 хувийг, Орон нутгийн хөгжлийн сангийн дуусаагүй ажлын авлага 26,068.0 мянган төгрөг буюу 11,0 хувийг, “Монгол-330” төслийн хүрээнд хийгдсэн бараа материалын авлага Засаг даргын тамгын газар дээр 3,879.6 мянган төгрөг буюу 0,2 хувийг, Эмийн эргэлтийн сангийн авлага 2,725.9 мянган төгрөг буюу 0,1 хувийг эзэлж байна. Авлага дансны жилийн эцсийн үлдэгдэл 234,647.7 мянган төгрөгийн 56,4 хувийг хувь хүмүүсээс авах авлага, 43,6 хувийг байгууллагаас авах авлага эзэлж байна.

Аудитын илрүүлэлт: Монголын баялаг-330 төсөл хөтөлбөрийн хүрээнд соёлын өвийг дүрсжүүлэн архив үүсгэх, ажлын гэрээ байгуулж гэрээний төлбөрт 3,879.6 мянган төгрөгийг шилжүүлсэн зөрчилд зөвлөмж өгч авлагыг санхүүгийн тайланд тусгуулж ажиллав.

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 178,514.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 40,293.7 мянган төгрөгөөр буюу 29,1 хувиар өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	54,130.77	56,420.56	2289.79
Эм боох материал	54,130.77	56,420.56	2,289.79
Хангамжийн материал	79,090.40	89,094.33	10,003.93
Бичиг хэргийн материал	572.00	690.20	118.20
Аж ахуйн материал	1,886.33	2,942.33	1,056.00
Сэлбэг хэрэгсэл	663.1	663.1	0.00
Түлш, шатах тослох материал	25.00	-	-25.00
Барилгын засварын материал	2,049.00	2049.00	
Хүнсний материал	-	-	0.00
Бусад хангамжийн материал	73,894.97	82,749.70	8,854.73
Мал амьтад	5,000.00	33,000.00	28,000.00
Дүн	138,221.17	178,514.89	40,293.72

Эх сурвалж: Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн бараа материалын тодруулга тайлан

Бараа материалын үлдэгдэл 178,514.9 мянган төгрөгийн 67,3 хувь буюу 120,735.3 мянган төгрөгийг Засаг даргын Тамгын газар, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 1,359.1 мянган төгрөг буюу 0,7 хувийг, Эмийн эргэлтийн сангийн 56,420.5 мянган төгрөг буюу 32 хувийг эм боох материал эзэлж байна. Бараа материал данс худалдан авсан 231,123.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 190,829.7 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар өгсөн илэрсэн, зөрчил байхгүй байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,311,243.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 188,527.3 мянган төгрөгөөр буюу 8,8 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,696,302.10	1,884,857.70	188,555.60
Барилга, байгууламж, орон сууц	1,136,427.00	1,119,411.30	-17,015.70
Авто-тээврийн хэрэгсэл	113,248.00	136,240.20	22,992.20
Машин тоног төхөөрөмж(компьютер)	171,945.30	165,724.50	-6,220.80
Тавилга, аж ахуйн эд хогшил	45,285.70	50,245.00	4,959.30
Бусад үндсэн хөрөнгө	229,396.10	413,236.70	183,840.60
Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00	0.00
Зам гүүрний байгууламж	0.00	0.00	0.00
Номын фонд	0.00	0.00	0.00
Биет бус хөрөнгө	426,414.30	426,386.00	-28.30
Программ хангамж	28.3	0	-28.30
Бусад биет бус хөрөнгө	426,386.00	426,386.00	0.00
Дүн	2,122,716.40	2,311,243.70	188,527.30

Эх сурвалж: Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн үндсэн хөрөнгийн тодруулга тайлан

Үндсэн хөрөнгө дансны жилийн эцсийн хөрөнгийн үлдэгдлийн 99,3 хувь буюу 2,294,488.5 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,4 хувь буюу 9,806.0 мянган төгрөгийг ИТХ, 0,3 хувь буюу 6,949.3 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эцэст 2,311,243.7 мянган төгрөг болж, худалдан авсан 26,272.4 мянган төгрөг, үнэ төлбөргүй авсан 79,695.0 мянган төгрөг, бусад 225,220.2 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, акталж устгасан 11,758.6 мянган төгрөгийн хөрөнгөөр буурсан байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 4,449.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,981.1 мянган төгрөгөөр буюу 35,6 хувиар буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

			/ мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	1,013.61	621.02	-392.59
Хувь хүмүүст төлөх өглөг	229.52	231.86	2.34
Дүн	1,243.13	852.88	-390.25

Эх сурвалж: Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өглөгийн тодруулга тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Засаг даргын тамгын газрын 103.0 мянган төгрөг, Эмийн эргэлтийн сангийн 87.3 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 365.7 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сан 231.9 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сан 65.0

мянган төгрөг нийт 852.88 мянган төгрөгийн өглөг байна. Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 852.8 мянган төгрөг болж, 390.25 мянган төгрөгөөр өмнөх оноос буурсан нь Эмийн эргэлтийн сангийн өр төлбөр буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчил байхгүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,350,029.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 494,521.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	716,990.20	716,990.20	0.00
Хуримтлагдсан үр дүн	1,807,988.06	2,491,453.08	683,465.02
Өмнөх үеийн үр дүн	5,272,456.70	1,807,537.34	-2,012,625.30
Тайлант үеийн үр дүн	-3,464,468.64	368,845.14	2,507,147.10
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	315,160.10	315,070.60	-
Дүн	2,840,138.36	3,208,443.28	368,304.92

Эх сурвалж: Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,208,443.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 368,304.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төв аймгийн Цээл сумын орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны төсвийн төсөлд хүргүүлсэн орлого, зардлыг тооцоолол, төлөвлөгөөг ирүүлээгүй болно.

Цээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 04 дүгээр тогтоолд зааснаар Цээл сумын Засаг дарга тайлант онд 319,287.2 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 778,216.3 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлгийг 279,095.9 мянган төгрөгөөр, орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 165,072.9 мянган төгрөг, сумын шилжих үлдэгдлийг 11,000.0 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн зардлыг 65,000.0 мянган төгрөгөөр нийт 1,552,672.3 мянган төгрөгөөр зардлыг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Цээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 05 дугаар тогтоолд зааснаар Цээл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд орон нутгийн орлогыг 365,912.3 мянган төгрөг буюу 46,625.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр

тодотгон баталж гүйцэтгэлээр 392,692.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 113,2 хувиар биелүүлсэн байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх орлого нийт 15,506.12 мянган төгрөгөөр үүнээс үйл түрээсийн орлого 1,637.7 мянган төгрөгөөр суутган-2 4,968.6 мянган төгрөгөөр, ойн нөөцийн төлбөр 1,963.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн орлого 3,874.34 мянган төгрөг, торгуулийн орлогыг 3,062.2 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

Төв аймгийн Цээл сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 05 дугаар тогтоолоор Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 67,096.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 1,014,394.3 мянган төгрөгөөр тодотгон, шилжих үлдэгдлийн төлөвлөгөөнд 48,700.0 мянган төгрөгөөр өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 17 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 1,397,184.2 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 653,355.0 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 496,590.8 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 67,348.0 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн санд 100 жилийн ойн хандив, тусламжийн эх үүсвэр 500,000.0 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвараас хийгдэх хөрөнгө оруулалт 18,500.0 мянган төгрөг, сумын орон нутгийн давсан орлогоос төсвийн шилжих үлдэгдэлд 528,384.6 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 140,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,566,628.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 41,266.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулахад 1,464,626.3 мянган төгрөг буюу 82,7 хувьтай байна. Энэ нь урсгал зардал 33,164.5 мянган төгрөг, хөрөнгийн зардал 255,753.2 мянган төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн гүйцэтгэл 24,540.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, 26 арга хэмжээнд 836,727.9 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 747,852.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-үндсэн үйл ажиллагааны зардал	112,067.90	111,839.70	-228.20	99.80
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- үндсэн үйл ажиллагааны зардал	643,517.60	614,197.30	-29,320.30	95.44
3	Ерөнхий боловсролын сургууль-тогтмол зардал	211,775.50	211,043.40	-732.10	99.65
4	Сургуулийн өмнөх боловсрол-тогтмол зардал	57,195.50	56,764.00	-431.50	99.25
5	Соёлын үйлчилгээ-тогтмол зардал	79,154.90	76,702.40	-2,452.50	96.90
6	Эрүүл мэндийн төв-тогтмол зардал	37,751.30	37,751.30	0.00	100.00
7	Хоршоо хөгжүүлэх сан- үндсэн үйл ажиллагааны зардал	65,000.00	40,460.00	-24,540.00	62.25
8	Орон нутгийн хөгжлийн сан-хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	571,621.20	315,867.92	-255,753.28	55.26
	Дүн	1,778,083.90	1,464,626.02	-313,457.88	708.55

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны захирагчаас 100,078.0 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 25,280.2 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив 9,416.0 мянган төгрөг нийт 134,774.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Цээл сумын Засаг дарга тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 142,876.7 мянган төгрөг зарцуулж, 32,308.2 мянган төгрөг буюу Засаг даргын тамгын газар 8,078.8 мянган төгрөг, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 28.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 9 хөтөлбөрийн 17 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангах, ИТХ, тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж, шаардлагатай мэдээллээр тасралтгүй хангахад оршино.	Сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хурлын үйл ажиллагааг тасралтгүй мэдээллээр ханган хэвийн үйл ажиллагааг ханган явуулсан байна. Хэрэгжилт 100%	112,067.9	111,839.7
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Төр засгийн бодлого шийдвэрийг сурталчилж хэрэгжилтийг хангах,иргэдэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй чанартай хүртээмжтэй хүргэх, ТАХ-чид хариуцсан салбар, нэгжийнхээ үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажиллана	төрийн бодлого шийдвэр хууль тогтоомжийг хэрэгжүүлэн сурталчилан таниулах үйл ажиллагааг явуулж төрийн албаны үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд хүргэж, иргэд, удирдлагуудыг мэдээллээр шуурхай үйлчилж ажилласан байна. Хэрэгжилт 95,6%	643,517.6	614,197.3
3	70106- Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	Хоршооны үйл ажиллагааг дэмжин ажиллах	төсөл сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулан 2 хоршоо, 1 иргэнд зээл олгон ажилласан байна. Хэрэгжилт 43,1%	65,000.0	40,460.0
4	71802- Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	Энэ хичээлийн жилд 75 хүүхдийн дотуур байр ашиглалтад оруулж сурагчдын сурч боловсрох таатай орчин бүрдүүлэн ажиллана	Хэрэгжилт 100%	211,775.50	171,285.7
5	71801- Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	БШУЯ-наас гаргасан чиглэлийн дагуу хүүхдийг зайны сургалтанд 94%-тай хамруулан агуулгын хоцрогдлыг нөхөн ажиллана.	Мөн багшийн хөгжилд анхааран сургалт зөвлөгөөнд хамруулан ажиллаж боловсролын үнэлгээгээр 98%	57,195.5	56,764.0
6	71702- Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Соёл урлагийн олон талт үйл ажиллагаа болон нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	Соёл урлагийн олон талт үйл ажиллагааг сурталчилах ажлыг 3 удаа зохион байгуулан, хэрэгжилт	79,154.9	76,702.4
7	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01 2023.12.31	Хэрэгжүүлж байгаа 9 хөтөлбөр, 3 бодлогын хүрээнд НЭМ-ийн	хэрэгжилт 100%-тай байна.	37,751.3	37,751.3

			тусламж үйлчилгээ үзүүлж сургалт сурталчилгаа хийнэ.			
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	2023.01.01 2023.12.31	Сумын хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэх	ОНХСангийн төсөл хөтөлбөрөөр 8 хөрөнгө оруулалтын ажил, 2 хөтөлбөр хэрэжин ажилласан байна.	571,621.20	391,127.60

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг 356,219.6 мянган төгрөгөөр, урсгал төсвийн хөрөнгөөр 298,608.2 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 54,500.0 мянган төгрөг нийт 709,327.7 мянган төгрөгийг төлөвлөсөн байна. Тухайлбал Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Нийтийн халуун усны их засвар”-ын ажлыг харьцуулалтын аргаар тендер шалгаруулж Их уул лүн ХХК 69,300.0 мянган төгрөгөөр, гэр хорооллын айл, өрхийг төвлөрсөн халаалтад холбох ажлыг мөн харьцуулалтын аргаар тендер шалгаруулж Алтан сэвсүүл ХХК 99,800.0 мянган төгрөгөөр, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хог тээвэрлэх автомашиныг харьцуулалтын аргаар тендер шалгаруулан 45,000.0 мянган төгрөгөөр тус тус төсөвт өртөгтөө багтаан хийж гүйцэтгэсэн байна. Эдгээр ажлуудыг шууд худалдан авалтын гэрээ байгуулах, нээлттэй тендер шалгаруулах, харьцуулалтын аргуудыг ашиглан худалдан авах ажиллагааны журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж хөрөнгө, материалыг данс бүртгэлд тусгаж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн данстай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 04-ны өдрийн 02/44 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын тайлангийн 2,590,929.6 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 38,869.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 29,148.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Цээл сумын Засаг дарга тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвийн жилд цалин хөлс, НДШ-ийн зардал 12,101.6 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой зардал 38,472.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 508.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 428.2 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 13.6 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 6,385.8 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 88,359.3 мянган төгрөг, урсгал шилжүүлэг 2.0 мянган төгрөг, хөрөнгийн зардал 507,697.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 178 мэдээлэл байршуулахаас 168 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 10 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 52,330.3 мянган төгрөгийн 2 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 321,695.6 мянган төгрөгийн 12 мэдээллийг байршуулаагүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой 20 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”, 6 дугаар зүйлийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төв аймгийн Цээл сумын Засаг дарга тайлант онд мод бэлтгэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 7 аж ахуй нэгж байгууллагатай 47,000.0 мянган төгрөгийн нийгмийн хариуцлагын гэрээг байгуулснаас 7 аж ахуй нэгж байгууллага гэрээний үүргээ биелүүлж 100,0 хувь буюу 47,000.0 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлсэн байна

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Цээл сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 296,225.6 мянган төгрөг, гүйцэтгэлээр 295,418.7 мянган төгрөг төвлөрсөн ба 16 нэр төрлийн орлогоос 7 нэр төрлийн орлого 40,628.0 мянган төгрөгөөр тасарсан, Шилэн данстай холбоотой 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Цээл сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 05/60 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	296,225.6	2	296,225.6	100
Нийт дүн	2	296,225.6	2	296,225.6	100

/мянган төгрөгөөр/

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Цээл сумын “Түүхт 100 жилийн ой 2024 онд тохиож байгаатай холбогдуулан иргэд, аж ахуй нэгж байгууллагаас өгсөн хандив тусламжийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнал, Орон нутгийн хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд иргэдийн санал санаачлагыг тусгаж эрэмбэлсэн эсэх, гүйцэтгэл, тендер шалгаруулалтай холбоотой асуудлуудыг анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 426,371.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 426,371.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага 1 зөвлөмж өгсөн.

5.2 Албан шаардлага

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын батлагдсан төлөвлөгөө 365,912.3 мянган төгрөг, гүйцэтгэлээр 392,692.8 мянган төгрөг төвлөрсөн ба 16 нэр төрлийн орлогоос 5 нэр төрлийн орлого 15,506.1 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

5.1 Зөвлөмж

Илрүүлэлт:

1. Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр ЗГУМС-тэй тулган баталгаажуулахгүй өр, авлагыг бүрэн тусгаж мэдээлэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-д “Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил бүтэн жилээр бэлтгэ тайлагнана”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр Төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу холбогдох маягтаар гаргуулан авч хянан баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ирүүлнэ” заалтын дагуу ирүүлж, зөвлөмж болон албан шаардлагын биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
4	Эмийн эргэлтийн сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	6	2	4		2			

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/										
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	5,387.60			1	5,387.60	1	5,387.60		
Засаг даргын Тамгын газар	2	110,479.10			2	110,479.10	2	110,479.10		
Дүн	3	115,866.7	0.0	0.0	3.0	115,866.7	3.0	115,866.7	0.0	0.0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл									
/мянган төгрөгөөр/									
Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Засаг дарга	2	426,371.20					1	0.00	
Засаг даргын Тамгын газар	4	666,775.90	2	13,455.00	1	649,440.00	1	3,879.60	
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	4	104,531.50	2	2,869.00	2	101661.6			
Хоршоо хөгжүүлэх сан	1	218,521.40					1	218,521.40	
Дүн	11	1416200	4	16,324.00	3	751101.6	3	222,401.00	

